



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/98/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас:99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал.....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БУУЦАГААН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Ч.ЖАВЗАН ТАНАА

2020.02.27 № 1/191
танай _____ -ны № _____ -т
Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

003020144

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн.

1. Үндсэн хөрөнгийн дансны тээврийн хэрэгсэл, бараа материалын дансны тусгай зориулалтын материал, бусад хангамжийн материалын дансны тооллогын материал байхгүй, бичиг хэргийн материал зөрүүтэй тоологдсон.

2. Бараа үйлчилгээний бусад зардлаас 7500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлж, шууд зардлаар бүртгэсэн. Мөн хүнс, бусад хангамжийн материалын хоорондын тооцоонд 912.9 мянган төгрөгийн нэхэмжлэх зөрүүтэй байна.


Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд Оршин байх, Эрх ба үүрэг, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЭМТ-ийн дарга Ч.Жавзан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.18-аас 2020.02.19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.15-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Чадварлаг, оюунлаг, ажил хэрэгч, эвсэг багаар дамжуулан иргэд хамт олны дэмжлэгтэйгээр нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай жигд, хүртээмжтэй орчин үеийн анагаах ухааны тэргүүлэх чиг хандлага, ололт амжилтыг нэвтрүүлсэн улс аймгийн загвар эрүүл мэндийн төв болоход оршино” гэж тодорхойлжээ.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв 2019 онд “Эх хүүхдийн эрүүл мэндийг тэргүүнд үзэж, эрүүл аюулгүй орчинд эрүүл монгол хүнийг бий болгох” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 32 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 570172,4 мянган төгрөгөөс тооцон 11403,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 11403,4 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50011,2 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	633.7	7,500.0	6,866.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	16,031.2	23,081.4	7,050.2
Үндсэн хөрөнгө	2,015,041.9	2,030,466.0	15,424.1
Хуримтлагдсан элэгдэл	(168,102.6)	(247,454.4)	(79,351.8)
Нийт хөрөнгө	1,863,604.2	1,813,593.0	(50,011.2)
Өр төлбөр	1,052.6	719.6	(333.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,862,551.6	1,812,873.3	(49,678.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,863,604.2	1,813,593.0	(50,011.2)

Авлагын дансны үлдэгдлийг 7500.0 мянган төгрөгөөр аудитын залруулга хийсэн бөгөөд бараа үйлчилгээний бусад зардлаас хүнс нийлүүлэгчид шилжүүлэн, бэлнээр гаргуулан авсан, зардал хэрэгжсэн эсэхийг нотлох боломжгүй байгаа тул зардлаар хүлээн зөвшөөрөх боломжгүй, хуулийн байгууллагад шалгагдаж байгаа болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 7050.0 мянган төгрөгөөр өссөн гол шалтгаан нь шатахууны зардлаас 2400.0 мянган төгрөг, Хүнсний зардлаас 800.0 мянган төгрөг, эм боох материалын данснаас эмийн зардлаас 1243,8, бусад хангамжийн материал бусад хангамжийн материал 2072.4, бичиг хэргийн материал 534.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 15424,1 мянган төгрөгөөр өссөн нь “Дэлхийн зэн” ОУБ-аас үнэ төлбөргүй 9746,6 мянга, бусад байгууллагаас 1350.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 8842.0 мянган төгрөг бэлтгэж, 8935,6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Хуримтлагдсан элэгдлийн данс нь тайлант оны элэгдлийн зардал 88217,4 мянган төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгө акталсантай холбоотойгоор 8865,6 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 719,6 мянган төгрөг болж 333.0 0 мянган төгрөгөөр буурсан нь оны эхэнд “Баянхонгор хайрхан фарм” ОНӨАТҮГ-т 548,1 мянга, Петровис ХХК-д 52,2 мянган төгрөгийн өглөг байсныг бүрэн барагдуулсан бөгөөд аймгийн ЭМГ-т 719,6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан нь нягтлан бодогч цаг тухай бүрт нь тооцоог барагдуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1812873,3 мянган төгрөг болж 49678,3 мянган төгрөгөөр буурсан нь тайлан үеийн үр дүн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд өөрийн орлого төлөвлөөгүй байна.

Тайлант онд нийт 512811,3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас төсвөөс 475640,5 мянга, ЭМД-ийн сангаас 31170,0 мянган төгрөг авахаар батлагдсан ба гүйцэтгэлээр төсвөөс олгох санхүүжилтийг бүрэн олгож ЭМД-аас 20750,1 мянган төгрөгийн санхүүжилт авч 16420,7 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна. Оны эцэст хэмнэгдсэн зарцуулаагүй зардлын үлдэгдэл 12801,4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 483589,2 мянган төгрөг буюу 94,3 хувьтай байна. Энэ нь ЭМД-аас гүйцэтгэлээр нь санхүүжүүлснээс 16420,7 мянган төгрөг дутуу санхүүжигдэн, дараах зардлын санхүүжүүлэх эх үүсвэрийн эрх нээгдээгүйтэй холбоотой байна.

Нийт эмийн зардал 10066,9 мянга, хоол хүнсний зардал 2955,5 мянга, тээвэр шатахууны зардал 4006,9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 9529,0 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2634,1 мянган төгрөгийн орлого орсноос 2535,0 мянган төгрөгийг СХАА-ны акт тогтоож оруулсан ба Аймгийн ЭМГ-аас сорьц тээвэрлэлтийн зардлаар 99,1 мянган төгрөг шилжиж ирсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлогоор 1548,3 мянган төгрөгийг халаалтын өрөнд, 543,5 мянган төгрөгийг НДШ-д, 443,2 мянган төгрөгийн аймгийн хүү торгуулийн орлогод, 59,4 мянган төгрөгийг сорьц тээвэрлэх зардалд зарцуулж, оны эцэст 39,7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар бараа үйлчилгээний бусад зардлаас 7500.0 мянган төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрөх боломжгүй, цагдаагийн эдийн засгийн албанд шалгагдаж байгаа тул авлагаар залруулав.

Аудитаар нийт 60042,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 58493,7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 1548,3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1548,3	
2	Албан шаардлага	1	58493,7	
	Дүн	2	60042,0	

Аудитаар 58493,7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа илэрсэнд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Бараа материалын тайлангийн Тусгай зориулалтын материал, Бусад хангамжийн материал, үндсэн хөрөнгийн дансны Тээврийн хэрэгслийн дансны тооллогын материал байхгүй, бичиг хэргийн материал зөрүүтэй нийт 58493,7 мянган төгрөгийн хөрөнгө тоологдоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалттай нийцэхгүй, "оршин байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Иргэн Л.Баярнямд 2019.12.26-нд Бараа үйлчилгээний бусад зардлаас 7500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй "сургалтанд" гэсэн гүйлгээг шилжүүлж тодруулахад Л.Баярнямаас тухайн 7500.0 мянган аймгийн ЭМГ-ын няравт бэлнээр өгсөн гэсэн тайлбар өгсөн. Дээрх асуудал нь цагдаагийн эдийн засгийн албанд шалгагдаж байгаа гэсэн тайлбарыг нягтлан бодогч Д.Мөнхтуяа өгөв.

Иймд дээрх 7500.0 мянган төгрөгийг авлагаар залруулсан бөгөөд тухайн асуудлын шийдэвлэгдсэн байдлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Тайлант хугацаанд нийт 151 мэдээлэл байршуулахаас 35 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан 2 мэдээллийг байршуулаагүй байсныг аудитын явцад мэдээлүүлэв.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	31	5	0
5	Тухай бүр	8	96	68	28	0
6	Нийт	27	151	114	35	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд аудитаар зөвлөмж, акт, албан шаардлага өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл*

1.1. Илрүүлэлт:

"Өлзийтийн нөмөрт хайрхан" хоршоонд өмнөх оны 1548.3 халаалтын өртэй байсныг шилжүүлсэн гэх боловч өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна. Тухайн хоршоо нь СХАА-нд хүсэлт тавин шалгуулж дээрх өглөгийг төлөх нь үнэн эсэхийг баталгаажуулсан.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Харилцагчидтай хийх тооцоог цаг тухай бүрд нь хийж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан бүртгэлийг үнэн зөв хөтөлж, тайланд авлага, өглөгийг бүрэн тусгаж Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,664,939.00</u>	<u>30,581,429.00</u>
33	АВЛАГА	633,720.00	7,500,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	633,720.00	00.00
335	Бусад авлага	00.00	7,500,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	7,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,031,219.00	23,081,429.00
351	Түүхий эд материал	160,000.00	3,803,810.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	2,400,000.00
35130	Эм боох материал	160,000.00	1,403,810.00
354	Хангамжийн материал	15,871,219.00	19,277,619.00
35410	Бичиг хэргийн материал	187,000.00	721,000.00
35460	Хүнсний материал	00.00	800,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,684,219.00	17,756,619.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,846,939,275.35</u>	<u>1,783,011,542.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,846,939,275.35	1,783,011,542.12
392	Биет хөрөнгө	1,821,551,275.35	1,757,623,542.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,739,069,245.55	1,739,069,245.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,269,897.47	-63,954,078.51
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,350,000.00	38,150,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,108,414.90	-12,970,914.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	151,429,760.81	164,222,353.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-114,328,133.23	-129,553,959.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,996,918.51	62,828,379.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,746,203.92	-40,325,483.01
39217	Ном	158,000.00	158,000.00
393	Биет бус хөрөнгө	25,388,000.00	25,388,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,038,000.00	26,038,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-650,000.00	-650,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,863,604,214.35</u>	<u>1,813,592,971.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,052,611.00</u>	<u>719,631.07</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,052,611.00	719,631.07
413	Өглөг	1,052,611.00	719,631.07
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,052,611.00	719,631.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,862,551,603.35</u>	<u>1,812,873,340.05</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,862,551,603.35	1,812,873,340.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	403,539,875.00	403,539,875.00
51101	Өмч: - төрийн	403,539,875.00	403,539,875.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,432,238,901.09	1,382,560,637.79
51210	Өмнөх үеийн үр дүн	1,432,238,901.09	1,430,690,616.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-48,129,978.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,772,827.26	26,772,827.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,863,604,214.35</u>	<u>1,813,592,971.12</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	464,584,915.00	514,542,396.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,690,000.00	15,517,676.78
120	Нийтлэг татварын бус орлого	31,690,000.00	15,517,676.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,690,000.00	15,517,676.78
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,690,000.00	15,517,676.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,526,415.00	105,182,620.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	395,368,500.00	393,842,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,006,258.00	2,634,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,006,258.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,634,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	81,798,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	81,798,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,520,157.00	20,750,120.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	16,520,157.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	20,750,120.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	535,515,231.13	562,672,375.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	535,515,231.13	562,672,375.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,581,316.13	549,831,283.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,671,196.00	287,492,239.00
210101	Үндсэн цалин	232,997,100.00	287,492,239.00
210104	Урамшуулал	10,674,096.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,266,246.00	35,955,596.00
210201	Тэтгэврийн даатгал	20,070,817.00	23,657,776.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,434,361.00	3,359,242.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,956,433.00	2,487,392.00
210204	Ажилгүйдлийн даатгал	436,784.00	601,971.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,367,851.00	5,849,215.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,326,438.00	77,026,237.00
210301	Гэрэл, цахилгаан	2,218,131.00	2,500,185.00
210302	Түлш, халаалт	53,768,307.00	74,126,052.00
210303	Цэвэр, бохир ус	3,340,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,244,805.00	19,253,371.12
210401	Бичиг хэрэг	3,221,200.00	760,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,390,105.00	15,848,071.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,480,500.00	415,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,173,000.00	180,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	70,000.12
2105	Нормативт зардал	26,031,516.00	28,533,955.61
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,696,487.00	21,814,573.61
210502	Хоол, хүнс	5,985,879.00	4,144,482.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,349,150.00	2,574,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,124,490.00	851,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	121,500.00

**Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210604	Урсгал засвар	4,124,490.00	730,000.00
2107	Томилолт, зочны зардал	950,000.00	818,000.00
210702	Дотоод албан томилолт	950,000.00	818,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	394,500.00	459,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,700.00	59,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	222,300.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	142,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,572,125.13	99,440,984.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,481,600.00	11,178,574.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	45,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,090,525.13	88,217,409.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,933,915.00	12,841,091.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,933,915.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	16,520,157.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,413,758.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	39,700.00
213404	Хөрөнгийн	00.00	39,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	12,801,391.66
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	12,801,391.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-70,930,316.13	-48,129,978.30
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	578,669,244.66	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,472,342.60	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	577,196,902.06	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-578,669,244.66	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-649,599,560.79	-48,129,978.30

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	432,894,915.00	499,024,720.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	432,894,915.00	499,024,720.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	395,368,500.00	393,842,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,006,258.00	2,634,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,006,258.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,634,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	81,798,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	81,798,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,520,157.00	20,750,120.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	16,520,157.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	20,750,120.00

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	432,894,915.00	499,024,720.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	432,894,915.00	499,024,720.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,961,000.00	486,183,628.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,611,662.00	286,057,600.00
210101	Үндсэн цалин	185,468,262.00	214,497,691.00
210102	Нэмэгдэл	40,315,700.00	54,295,709.00
210104	Урамшуулал	18,827,700.00	17,264,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,959,500.00	35,769,800.00
210201	Тэтгэврийн даатгал	19,306,300.00	23,288,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,413,300.00	3,255,469.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,930,600.00	2,487,392.00
210204	Ажилгүйдлийн даатгал	482,700.00	561,097.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,826,600.00	6,177,642.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,344,938.00	77,026,237.00
210301	Гэрэл, цахилгаан	2,256,631.00	2,500,185.00
210302	Түлш, халаалт	53,768,307.00	74,126,052.00
210303	Цэвэр, бохир ус	3,320,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,172,100.00	21,994,390.80
210401	Бичиг хэрэг	980,000.00	2,364,510.80
210402	Тээвэр, шатахуун	16,079,900.00	16,701,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,400.00	948,400.00
2105	Нормативт зардал	26,715,900.00	30,937,780.54
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,714,121.00	23,339,118.54
210502	Хоол, хүнс	5,985,879.00	4,944,482.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,015,900.00	2,654,180.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,150,000.00	9,220,220.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,050,000.00	3,711,020.00
210602	Тавилга	00.00	2,109,200.00
210604	Урсгал засвар	2,100,000.00	3,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	950,000.00	818,000.00
210702	Дотоод албан томилолт	950,000.00	818,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,200.00	2,994,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,700.00	2,594,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,878,700.00	21,365,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,878,700.00	21,365,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,933,915.00	12,841,091.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,933,915.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	16,520,157.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,413,758.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	39,700.00
213404	Хөрөнгийн	00.00	39,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	12,801,391.66
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	12,801,391.66
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/төгрөг/
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,432,238,901.09	00.00	1,862,551,603.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-1,548,285.00	00.00	-1,548,285.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,430,690,616.09	00.00	1,861,003,318.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-48,129,978.30	00.00	-48,129,978.30
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	403,539,875.00	26,772,827.26	1,382,560,637.79	00.00	1,812,873,340.05

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	379,666,100.00	379,639,666.00	512,811,300.00	483,589,228.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	512,811,300.00	483,589,228.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,035,100.00	369,008,666.00	512,811,300.00	483,589,228.34
210101	Үндсэн цалин	214,887,000.00	214,866,826.00	214,491,100.00	214,497,691.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	54,302,300.00	54,295,709.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,858,800.00	2,306,166.00	3,120,400.00	3,255,469.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,288,700.00	1,844,932.00	2,496,300.00	2,487,392.00
210204	Ажилгүйдлийн даатгал	460,800.00	461,234.00	624,100.00	561,097.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,608,600.00	4,612,330.00	6,240,800.00	6,177,642.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,160,200.00	54,160,200.00	78,398,400.00	77,026,237.00
210301	Гэрэл, цахилгаан	4,027,000.00	4,027,000.00	4,749,400.00	2,500,185.00
210302	Түлш, халаалт	49,189,100.00	49,189,100.00	73,249,000.00	74,126,052.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,814,100.00	17,814,100.00	25,924,400.00	21,994,390.80
210401	Бичиг хэрэг	971,600.00	972,000.00	1,200,000.00	2,364,510.80
210402	Тээвэр, шатахуун	14,586,000.00	14,585,600.00	20,708,400.00	16,701,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	733,400.00	733,400.00	2,016,000.00	1,980,000.00

**Бууцаган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,523,100.00	1,523,100.00	2,000,000.00	948,400.00
2105	Нормативт зардал	26,672,800.00	26,672,600.00	44,321,900.00	30,937,780.54
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,081,700.00	18,081,700.00	33,406,000.00	23,339,118.54
210502	Хоол, хүнс	6,400,000.00	6,400,000.00	7,900,000.00	4,944,482.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,191,100.00	2,190,900.00	3,015,900.00	2,654,180.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,438,800.00	3,438,800.00	9,225,000.00	9,220,220.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,185,400.00	2,185,400.00	4,425,000.00	3,711,020.00
210602	Тавилга	00.00	00.00	1,400,000.00	2,109,200.00
2107	Томилолт, зочны зардал	945,500.00	945,500.00	1,820,000.00	818,000.00
210702	Дотоод албан томилолт	945,500.00	945,500.00	1,820,000.00	818,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10079600.00	10079590.00	30894200.00	21365200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,079,600.00	10,079,590.00	30,894,200.00	21,365,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	512,811,300.00	483,589,228.34
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	393,842,100.00	382,412,871.34
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	379,666,100.00	379,639,666.00	393,842,100.00	382,412,871.34
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	81,798,400.00	80,426,237.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	81,798,400.00	80,426,237.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	37,170,800.00	20,750,120.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	37,170,800.00	20,750,120.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29	29.00	28.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	19.00	18.00

Нэмэлт санхүүжилт:

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	2634100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2634100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2634100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	2634100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2634100.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	2634100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2634100.00
132002	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	2634100.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Б.АЗБАЯР 2020.02.27

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ 2020.02.27

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2020.02.27